



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/269

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээнээс  
хамтран эзэмшигч хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Иргэн Хариад овгийн Пүрэвжавын Эрдэнэ-Очир (РЮ65060513), иргэн Цогнууд овгийн Лхагвасүрэнгийн Дэнсмаа (РЮ89103106) нарын Мөрөн сумын 5 дугаар баг Зах-206 хаягт байршилтай худалдаа, нийтийн үйлчилгээний зориулалттай 6712017091 нэгж талбар бүхий 4709м<sup>2</sup> эзэмшил газрын газар эзэмших эрхийн гэрчилгээнээс газар эзэмшигч иргэдийн өөрсдийнх нь хүсэлтийн дагуу хамтран эзэмшигч иргэн Пүрэвжавын Эрдэнэ-Очирыг хамтран эзэмшигчээс хасаж, газар эзэмших эрхийг Лхагвасүрэнгийн Дэнсмаа (РЮ89103106)-ийн нэр дээр үлдээн, үлдсэн 20 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Уг захирамж гарсантай холбогдуулан Пүрэвжавын Эрдэнэ-Очирыг газар эзэмших эрхийг улсын бүртгэлээс хасалт хийж, Лхагвасүрэнгийн Дэнсмаатай газар эзэмших эрх зүйн баталгаажилт шинээр хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3.Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

6712010843